



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 08 сарын 10 өдөр

Дугаар 98


Улаанбаатар хот

### “Эм Ви Эй Эф” хувийн хөрөнгө оруулалтын санг бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2, 55 дугаар зүйлийн 55.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 436 дугаар тогтоолоор баталсан “Хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны тухай журам”-ын 8.1.2, 8.4.12 дахь заалт, “Эм Ви Эй Эф хувийн ХОС” ХХК-ийн нэгж эрх эзэмшигчийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 19/009 дүгээр шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мастер инвестмент менежмент ҮЦК” ХХК-ийн үүсгэн байгуулсан “Эм Ви Эй Эф” хувийн хөрөнгө оруулалтын санг бүртгэлээс хассугай.
2. “Эм Ви Эй Эф” хувийн хөрөнгө оруулалтын санг татан буулгах ажлыг холбогдох хууль, журмын хүрээнд хэрэгжүүлэхийг “Эм Ви Эй Эф хувийн ХОС” ХХК-ийн татан буулгах ажлын хэсэг /Б.Цогтбаяр/-т анхааруулсугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын албанд ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН